



## “ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР”

ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

Найрамдал талбай, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61027

Утас: 976 (757) 7 35 01, Факс: (976) 7035 3002,

Цахим шуудан: info@erdenetmc.mn,

Цахим хаяг: www.erdenetmc.mn

8024.05.29 № СГ-112-12/3216

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Гэрээ байгуулах эрх олгосон мэдэгдлийг  
түр хугацаагаар түдгэлзүүлэх тухай

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас зарласан “Цахиурт кальци” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ЭҮТӨҮГ/20240202048 дугаартай тендер шалгаруулалтад оролцсон “ЦСМБ” ХХК-аас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.6 дахь хэсэг, Сангийн яамны 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам” (цаашид “журам” гэх)-ын 4.1-д заасны дагуу гомдол гаргасан тул Сангийн яамны 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 03/4047 дугаартай албан бичгээр гүйцэтгэгч сонгох ажиллагааг 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн түр хугацаагаар түдгэлзүүлсэн болохыг мэдэгдье.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДАН  
АВАХ АЖИЛЛАГААНЫ БОДЛОГЫН  
ГАЗРЫН ДАРГА



С.ЭНХМАНДАХ



"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН  
ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАРТ

## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,  
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот.  
Утас/факс: (976-51) 26 74 68. Цахим шуудан: info@mof.gov.mn.  
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>.

2024.05.20 № 03/4047  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Тендер шалгаруулалтыг түдгэлзүүлэх тухай

Танай байгууллагаас зарласан ЭҮТӨҮГ/ 20240202048 дугаартай "Цахиурт кальци" нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтад оролцсон "ЦСМБ" ХХК-аас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид "хууль" гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалаар баталсан "Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам" (цаашид "журам" гэх)-ын 4.1-д заасны дагуу гомдол гаргасан байна.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.6 дахь хэсгийг үндэслэн захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлж байна.

Иймд гомдлыг хянан шийдвэрлэхэд шаардлагатай дараах баримт бичгийг 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн дотор ирүүлнэ үү. Үүнд:

1. Батлагдсан төсөвт өртгийн шийдвэрийн хуулбар;
2. Үнэлгээний хороо байгуулсан шийдвэр;
3. Батлагдсан тендер шалгаруулалтын баримт бичиг;
4. Оролцогчдын ирүүлсэн тендер /Тендер нээх нууц үг/;
5. Тендерийн нээлтийн тэмдэглэл;
6. Үнэлгээний хорооны зөвлөмж, хурлын тэмдэглэл;
7. Оролцогч болон бусад байгууллагуудтай харилцсан бичиг;
8. Гэрээ байгуулах эрх олгох, шалгараагүй болон татгалзсан тухай шийдвэр;
9. Захиалагч гомдол хянан шийдвэрлэсэн бол холбогдох шийдвэр;
10. Холбогдох бусад баримт бичиг.

Түүнчлэн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.9 дэх хэсэгт заасны дагуу бусад оролцогч нарт энэхүү мэдэгдлийн тухай мэдээлэх арга хэмжээ авахыг үүгээр мэдэгдэж байна.

Гомдлыг хянан шийдвэрлэх хугацаанд хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасан хугацаа зогсох болно.

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Ж.ГАНБАТ

9766007038